Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2025.02.24

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Ерөнхийлөгч Дональд Трамп Орос-Украины мөргөлдөөнийг зогсоох оролдлого хийхийн зэрэгцээ автомашин, эмийн бүтээгдэхүүн, модон материалд нэмэлт тариф ногдууллаа.
- Walmart-ийн хувьцаа пүрэв гарагт 6.53%-иар унасан байна.
- Илон Маск холбооны бүх ажилчдад и-мэйл илгээх гэж буйгаа зарлалаа. Уг и-мэйлээр тэднээс өнгөрсөн долоо хоногт хийсэн ажлын амжилт, үр дүнг тайлагнахыг шаардах юм.
- Хонконгт Hang Seng индекс 3.79%-иар өссөн нь Alibaba-ийн хувьцааны огцом өсөлттэй холбоотой байв.
- Ши Жиньпин Alibaba-ийн үүсгэн байгуулагч Жэк Ма болон бусад томоохон технологийн компанийн удирдлагуудтай уулзсан.

S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	**6,678**

АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.02.17-02.24

WALMART ТАЙЛАН САЙН ГАРСАН Ч УНАЛАА

Өнгөрөгч долоо хоногт Ерөнхийлөгчдийн өдрийг тохиолдуулан даваа гарагт зах зээл амарсан бөгөөд мягмар гарагт хувьцааны үнэ ерөнхийдөө өсөх хандлагатай эхэлж, S&P 500 индекс мягмар болон лхагва гарагт түүхэн дээд түвшинд хүрч хаагдсан. Гэвч долоо хоногийн сүүлийн хагаст гарсан огцом унаж, томоохон индексүүдийг доогуур хаагдахад хүргэлээ.

Энэ долоо хоногийн гол мэдээллүүд нь геополитик болон татварын бодлоготой холбоотой байв. Ерөнхийлөгч Дональд Трамп Орос-Украины мөргөлдөөнийг зогсоох оролдлого хийхийн зэрэгцээ автомашин, эмийн бүтээгдэхүүн, модон материалд нэмэлт тариф ногдуулахаар мэдэгдэл хийсэн боловч яг хэзээ гэдэг нь тодорхойгүй хэвээр байна.

Пүрэв гарагт зах зээлийн уналтын нэг шалтгаан нь Walmart-ийн 4-р улирлын тайлан байв. Тус компани зах зээлд хүлээгдэж байсан орлогын тоон үзүүлэлтүүдийг давсан боловч ирэх оны хүлээлт хангалтгүй байсан нь хөрөнгө оруулагчдын хэрэглээний зарцуулалт болон эдийн засгийн төлөв байдалд санаа зовох шалтгаан болжээ. Үүнээс өмнө Худалдааны яамны мэдээлснээр нэгдүгээр сард жижиглэн худалдааны үзүүлэлт сүүлийн хоёр жилд байгаагүйгээр унасан нь анхаарал татаж байсан. Walmart-ийн хувьцаа пүрэв гарагт 6.53%-иар унасан байна.

ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАНГАА ЯВУУЛ, ЭСВЭЛ ОГЦОР

Tesla (NASDAQ:TSLA) болон SpaceX-ийн гүйцэтгэх захирал Илон Маск холбооны бүх ажилчдад и-мэйл илгээх гэж буйгаа зарлалаа. Уг и-мэйлээр тэднээс өнгөрсөн долоо хоногт хийсэн ажлын амжилт, үр дүнг тайлагнахыг шаардах юм. Энэ алхам нь Ерөнхийлөгч Дональд Трампын гаргасан шийдвэр, чиглэлийн дагуу хийгдэж буй бөгөөд тэрээр Маскийг төрийн үйл хэрэгт идэвхтэй оролцохыг хүссэн билээ.

Ерөнхийлөгч @realDonaldTrump-ын зааврын дагуу холбооны бүх ажилчид удахгүй өнгөрсөн долоо хоногт хийсэн ажлаа тайлагнахыг хүссэн и-мэйл хүлээн авах болно, хэмээн Маск X сүлжээнд мэдэгдсэн байна. "Хэрэв хариу өгөхгүй бол огцорсонд тооцогдоно."

Өнөөдөр өглөө Ерөнхийлөгч Трамп Маскийн ажлыг сайшаасан ч түүнээс илүү түрэмгий, шийдэмгий хандлагатай байхыг уриалжээ. Трамп төрийн ажлын яаралтай, нэн чухал гэдгийг онцлон, "Бид улс орноо аварч, урьд байгаагүйгээр агуу болгох ёстой" гэж мэдэгдсэн. Маск Ерөнхийлөгчийн уриалгад нэн даруй хариу өгч, түүнтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн байна.

Ерөнхийлөгчийн хүсэлт, Маскийн авч буй арга хэмжээ нь төрийн байгууллагын бүтээмж, хариуцлагыг дээшлүүлэх гэсэн шинэ чиг хандлагыг илтгэж байна. Мөн энэ нь хувийн хэвшлийн удирдагчид, тэр дундаа Маск шиг хүмүүс төрийн үйл ажиллагаанд улам бүр их нөлөө үзүүлэх болсныг харуулж байна. Цаашид энэхүү шинэ динамик хэрхэн өрнөхийг харах л үлдлээ.

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.02.17-02.24

ШИ ДАРГА ЖЕК МА УУЛЗЛАА

Хятадын хөрөнгийн зах зээл өнгөрөгч долоо хоногт өсөлттэй байлаа. Технологийн томоохон компаниудын хүлээлтээс давсан ашиг зарласны дараа технологийн салбарын хувьцаанууд хүчтэй өсөлт үзүүлсэн нь үүнд голлон нөлөөлөв. CSI 300 индекс 1.00%-иар, Шанхайн нийлмэл индекс 0.97%-иар нэмэгдсэн гэж FactSet мэдээлэв.

Хонконгт Hang Seng индекс 3.79%-иар өссөн нь Alibaba-ийн хувьцааны огцом өсөлттэй холбоотой байв. Alibaba, цахим худалдаа болон үүлэн тооцооллын салбарт тэргүүлдэг тус компанийн 2023 оны 12-р улирлын борлуулалт хүлээлтээс хурдан өссөн нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээжээ.

Alibaba болон бусад Хятадын технологийн компаниудын санхүүгийн хүчтэй үзүүлэлт нь дотоодын хиймэл оюун ухааны стартап DeepSeek өнгөрсөн нэгдүгээр сард өөрийн технологийн чадамжаа харуулсны дараа гарсан нь интернетийн салбарт хөрөнгө оруулагчдын сонирхлыг дахин төрүүлсэн байна.

Мөн Ерөнхийлөгч Ши Жиньпин Хятадын томоохон технологийн бизнес эрхлэгчидтэй өндөр түвшний уулзалт хийсний дараа зах зээлд эерэг уур амьсгал бүрэлдэв. 2-р сарын 17-нд болсон уг уулзалтын зурагнууд төрийн мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд түгэж, Ши Жиньпин Alibaba-ийн үүсгэн байгуулагч Жэк Ма болон бусад томоохон технологийн компанийн удирдлагуудтай уулзаж байгаа нь харагдсан.

Жэк Магийн ил гарч ирсэн нь онцгой ач холбогдолтой үйл явдал байв. Тэрээр Хятадын технологийн салбарын тэргүүлэх төлөөлөгч байсан ч 2020 онд Alibaba-ийн түнш Ant Group-ийн IPO-г төр гэнэт зогсоосон нь олон жилийн турш үргэлжилсэн технологийн салбарын хяналт, хатуу бодлогын эхлэл болсон юм.

Гэвч сүүлийн үед хувийн хэвшлийг Хятадын эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр хэмээн онцлох болсон. Учир нь тус улсын эдийн засаг үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт, дотоод эрэлт сулрах зэрэг бэрхшээлтэй нүүр тулж байна. Иймд технологийн компаниудын өсөлт нь эдийн засагт эерэг нөлөөг авчрах нь дамжиггүй.

АЛИБАБА ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Тайлангаас үзэхэд, нийт орлого 280.15 тэрбум юань хүрч, шинжээчдийн хүлээлтээс ялимгүй давсан үзүүлэлттэй гарчээ. Мөн Хятадын дотоодын цахим худалдааны бизнесийн орлого 136 тэрбум юань болж, 5%-ийн өсөлттэй гарлаа. Alibaba компани ирэх гурван жилийн хугацаанд хиймэл оюун ухаан болон үүлэн тооцооллын салбарт 380 тэрбум юань (ойролцоогоор 52.44 тэрбум ам.доллар) хөрөнгө оруулахаа мэдэгдсэн нь тус салбартай холбоотой хөрөнгө оруулалтаа эрчимжүүлж буйг харуулж байна. Энэ нь компанийн сүүлийн арван жилийн хугацаанд тус салбарт зарцуулсан нийт хөрөнгө оруулалтаас давсан хэмжээ аж. Түүнчлэн, Alibaba компани 2024 оны 11-р сард 5 тэрбум ам.долларын хоёр валютын бонд гарган, санхүүгийн нөөцөө өргөжүүлсэн нь зах зээлд тогтвортой байр суурьтай хадгалах стратегийн нэг хэсэг гэж үзэж болох юм. Эдгээр үзүүлэлтүүд нь Alibaba-ийн санхүүгийн тогтвортой байдал, өсөлтийн хэтийн төлөвийг эерэг байгааг харуулж байна.

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд